



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/1273

Улаанбаатар хот

Барилга акталж, данснаас
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Барилга акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай” 133 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 23 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй, нийт 165,555,284.00 (нэг зуун жаран таван сая таван зуун тавин таван мянга хоёр зуун наян дөрөв) төгрөгийн бүртгэлийн үнэ, 101,531,036.20 (нэг зуун нэг сая таван зуун гучин нэгэн мянга гучин зургаан төгрөг хорин мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан Спорт заалны барилгыг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 23 дугаар сургууль (Ш.Оюунсүрэн)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данс бүртгэлээс хасах барилгыг нурааж буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 16,625,272.00 (арван зургаан сая зургаан зуун хорин таван мянга хоёр зуун далан хоёр) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 23 дугаар сургууль (Ш.Оюунсүрэн), орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205912



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
сарын 09 өдрийн
захиралжийн
хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашигласан жил	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Спорт заал	46	Чингэлтэй дүүрэг 1 дүгээр хороо	111,824,317.00	25,414,617.60	86,409,699.40	Хотын Стандарт, хяналтын газрын Улсын байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02-13-01/036/61 дүгээр дүгнэлт
2	Цементэн суурьтай төмөр хашаа	9		13,266,375.00	3,491,151.60	9,775,223.40	
3	Зүлэгжүүлсэн талбай	9		18,312,550.00	18,312,550.00	-	
4	Хар мод	31		1,860,800.00	930,398.72	930,401.28	
5	Бут сөөг	31		3,060,000.00	1,530,026.16	1,529,973.84	
6	Төмөр хашаа	5		2,332,714.00	1,943,935.72	388,778.28	
7	Гүйлтийн зам талбай	9		8,239,968.00	8,239,968.00	-	
8	Биеийн тамирын талбай	5		6,658,560.00	4,161,600.00	2,496,960.00	
Нийт дүн				165,555,284.00	64,024,247.80	101,531,036.20	